



“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022 он



**АВЛИГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт
1	Монгол Улсын Засгийн газраас баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын индексийг бууруулах зорилтын хүрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын индексийг бууруулах ажлыг төвийн хэмжээнд зохион байгуулж, авлига, хүнд сурталтай тэмцэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, үр дүнг тооцон ажиллах;	- Ажлын хэсэг байгуулагдсан байх, - Үр дүнг тооцож, тайлагнасан байх;	I-IV улиралд	Монгол Улсын Засгийн газраас баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын индексийг бууруулах зорилтын хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын индексийг бууруулах ажлыг төвийн хэмжээнд зохион байгуулж, авлига хүнд сурталтай тэмцэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Төвийн захирлын 2022 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсгээс төвийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөт ажлуудын хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллаж байна.
2	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	- Мэдээллийн самбар хийлгэж, байршуулсан байх; - Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх;	I-IV улиралд	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс “Шударга ёс, хөгжил дэвшилд 110 самбар”-ыг ажиллуулж, мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжилт хийж, АТГ-аас зарласан аян, мэдээллүүдийг тухай бүр олон нийтэд хүргэн ажиллаж байна.

3	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэж, хүнд суртал гаргасан талаарх иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах утсыг тогтмол ажиллуулах;</p>	<p>- Гомдол, мэдээллийг бүртгэж, тоон мэдээлэл гарсан байх; - Удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авагдсан байх;</p>	Тухай бүр	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэж, хүнд суртал гаргасан талаарх иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах 11-320338 дугаарын утсыг тогтмол ажиллуулан, энэ талаарх мэдээллийг төвийн албан ёсны веб сайт болон фэйсбүүк хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Тус дугаарт ирсэн гомдол, мэдээллийг бүртгэлийн дэвтэрт хөтлөн, удирдлагад тухай бүр танилцуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.</p>
4	<p>Тус төвөөс иргэд, аж ахуй нэгж байгууллагатай байгуулах гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусган гэрээ, хэлэлцээрийг баталж хэвших;</p>	<p>Арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;</p>	I-IV улиралд	<p>Тус төвөөс иргэд, аж ахуй нэгж байгууллагатай байгуулах гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусган гэрээ, хэлэлцээрийг баталж хэвшсэн. Мөн боловсруулсан баримт бичгийн төсөлд “Санал өгөх хуудас”-нд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг тэмдэглэх хэсэг гарган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.</p>
5	<p>АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран байгууллагын удирдлагуудад чиглэсэн зорилтот сургалтыг зохион байгуулах;</p>	<p>Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоон мэдээлэл гарсан байх;</p>	I-III улиралд	<p>Авлигатай тэмцэх газраас 2022 онд зохион байгуулах авлигын эсрэг сургалтад 40 ажилтныг, шинээр томилогдсон албан тушаалтныг тухай бүр нь хамруулах саналыг тус газрын УССХГ-т хүргүүлж, сургалтын талаарх мэдээллийг солилцон хамтран ажиллаж байна. МУИС-ийн Олон Улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Нийтийн удирдлагын тэнхим,</p>

				<p>Төрийн удирдлагын хөтөлбөрийн багш, АТГ-ын сургагч багш Г.Мягмар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр төвийн нийт ажилтнуудад орж, мэдээлэл хүргэсэн. Мөн Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газраас 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг, УИХ-ын дэргэдэх парламентын судалгааны төвийн захирал Ц.Цогзолмаа 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг төвийн нийт ажилтнуудад орж, мэдээлэл хүргэсэн.</p> <p>Тус төв нь төрийн албан хаагчийн шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх байгууллагын соёлыг тогтоох зорилготой “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк пэйж хуудсанд байгууллагын 155 ажилтныг нэгтгэж, Авлигатай тэмцэх газраас Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Зөв зөвд шударга зөв аян”-д нэгдсэн болно.</p>
6	Барилгын салбарын үйлчилгээг цахимжуулах, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Барилгын салбарын нэгдсэн систем”-д хөгжүүлэлт хийх	“Барилгын салбарын нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлтийн ажил хийгдсэн байх;	I-IV улиралд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод, нээлттэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор 2020-2022 онд “Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим систем” www.mcis.gov.mn -

	<p>ажлыг оновчтой зохион байгуулах;</p>		<p>ийг хөгжүүлэн, үе шаттайгаар ашиглалтад оруулан ажиллаж байна. 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс тусгай зөвшөөрөл, норм норматив, сургалт судалгаа, хууль эрх зүй, нийтийн аж ахуй, лабораторийн шинжилгээ зэрэг дэд систем /модуль/-үүдийг ашиглалтад оруулсан.</p> <p>Тусгай зөвшөөрлийн системийг ашиглалтад оруулснаар барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, цахимаар олгож эхэлсэн бөгөөд цахимаар 2214 хүсэлт ирснээс 441 аж ахуйн нэгж байгууллагад тусгай зөвшөөрөл шинээр, сунгалтаар, нэмэлт ажлын төрлөөр олгогдсон байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй 5066, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй 788, өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй 179 аж ахуйн нэгж, байгууллага цахим системд бүртгэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Мөн тус цахим системийн олон нийтэд нээлттэй харагдах хэсэгт барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг жагсаалтаар байршуулсан.</p> <p>Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааны мэдээ тайланг хуулийн хугацаанд, батлагдсан</p>
--	---	--	---

				<p>маягтын дагуу цахимаар тайлагнах боломж бүрдсэн.</p> <p>Норм, нормативын системийг ашиглалтад оруулснаар Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 8 цогцолборын 375 норм дүрэм, баримт бичгийг орон зай, цаг хугацаа харгалзахгүй үнэ төлбөргүй татан авах, хэвлэх боломжтой болсон.</p> <p>Сургалт судалгаа системийг ашиглалтад оруулснаар барилгын салбарын инженер техникийн ажилтны мэргэшүүлэх сургалттай холбоотой мэдээ, мэдээлэл, зарыг олон нийтэд нээлттэй байршуулах, сургалтыг цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Мөн цахим системийн хөгжүүлэлт, нэмэлт ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн системийг хөгжүүлж, энэ төрлийн үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх боломжтой болж байна.</p>
7	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж, АТГ-аас бэлтгэсэн мэдээ мэдээлэл, зурагт хуудас, гарын авлга зэргийг иргэд, олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Барилгын мэдээлэл эмхэтгэл”-д авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх холбогдох мэдээллийг багтаасан булан гаргах;</p>	<p>“Барилгын мэдээлэл эмхэтгэл”-д авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг багтаасан булан ажиллуулж, олон нийтэд хүргэсэн байх;</p>	I-IV улиралд	<p>Тус төвөөс эрхлэн гаргадаг “Барилгын мэдээлэл эмхэтгэл”-ийн 4 дүгээр сарын цахим дугаарт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг А4 энгийн нүүрт багтаан нийтэлж олон нийтэд сурталчлан ажилласан.</p>

8	Төвөөс үзүүлж буй үйлчилгээний төлбөр хураамжийг чирэгдэл үүсгэхгүй байдлаар цахимаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;	Үйлчлүүлэгчээс авч байгаа төлбөр, хураамж боломжит байдлаар цахим хэлбэрт шилжсэн байх;	III улиралд	Байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийг чирэгдэл үүсгэхгүй байдлаар зохион байгуулж, цахимаар шийдвэрлэн ажиллаж байна. Тухайлбал, лабораторийн шинжилгээний төлбөр, зураг төсөл магадлалын хөлс, сургалтын төлбөр, технологийн заавар батлуулах хураамж, бүтээгдэхүүн баталгаажуулалтын төлбөр, орон сууц өмчлөлийн лавлагааны хураамж зэргийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн.
9	Гүйцэтгэл хянан баталгаажуулах ажлыг авлигын нөлөөллөөс ангид, бодит байдалд тулгуурлан гаргах, шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилга угсралтын явцыг камерын хяналтад холбох ажлыг зохион байгуулах;	14 аймаг, нийслэлийн 1 дүүрэг, нийт 16 төсөл арга, хэмжээг камерын хяналтад холбосон байх;	I-IV улиралд	Хөвсгөл, Дорнод, Завхан, Дундговь аймгийн 4 төсөл, арга хэмжээ камерын хяналтад бүрэн холбогдож, Увс, Хэнтий, Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Ховд аймгийн 9 төсөл арга хэмжээнд камерын хяналт тавих ажлын зураг, материалын тооцоог гаргаж, гүйцэтгэгч компанитай тохиролцсон бөгөөд камерын хяналтад холбоход бэлэн болсон.
10	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэх хүсэлт ирүүлсэн болон үйлчлүүлж буй иргэд, аж ахуй нэгж байгууллагаас магадлал хийх ажлыг хуулийн хугацаанд, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулсан эсэхийг тодруулах, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх зорилгоор товч асуулга бүхий “Сэтгэл ханамжийн судалгаа”-г	- Мэргэжилтэн тус бүр судалгаа авсан байх; - Судалгааг улирал бүр нэгтгэн, үр дүнг тооцсон байх;	Сар бүр	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэх хүсэлт ирүүлсэн болон үйлчлүүлж буй иргэд, аж ахуй нэгж байгууллагаас гар утсаараа QR код уншуулан, тус хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, гомдлыг цахим хэлбэрээр гаргах боломжтой болсон бөгөөд иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.

	авч, үр дүнг улирал бүр тооцон ажиллах;			
11	Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлагыг бууруулах, олон нийтэд ил тод байршуулах зорилгоор барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, нормативын баримт бичгийг иргэд, аж ахуй нэгж байгууллага үнэгүй үзэж, хэвлэх боломжоор хангаж цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, баяжилтын ажлыг тогтмол хийх;	- Норм, нормативын баримт 100 хувь цахимд шилжсэн байх; - Баяжилтын ажил тухай бүр хийгдсэн байх;	I-IV улиралд	Барилгын нэгдсэн мэдээллийн систем буюу MCIS.GOV.MN сайтад Монгол Улсад мөрдөгдөж байгаа барилгын салбарын 408 норм нормативын баримт бичгийг цахим хэлбэрээр байршуулсан. Салбарын инженер, техникийн ажилтан, оюутан залуучууд орон зай хамаарахгүйгээр байгаа газраасаа энэхүү цахим мэдээллийн санд нэвтрэн орж Монгол Улсын норм нормативын баримт бичигтэй танилцах, ашиглах боломжтой болсон. Тухайлбал, 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар БНБД 22-01-21 “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм дүрмийг 1026 удаа, бусад баримт бичгийг 10-377 удаа татаж үзсэн байна. Мөн иргэдээс 22 санал, хүсэлт, асуултыг ирүүлж, холбогдох хариуг өгч ажилласан. “Барилга байгууламжийн норм нормативын сан”-д тусгагдан боловсруулагдаж буй баримт бичгийн төсөлд тухай бүр олон нийт болон холбогдох газруудаас санал авч, шинээр батлагдсан норм, дүрмийн танилцуулга, хичээлийг видео хэлбэрээр байршуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна.
12	Үнэн бодитой мэдээллийн бааз үүсгэж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын хэмжээнд шинээр ашиглалтад орсон болон ашиглалтад	- Орон сууцны мэдээллийн судалгааг тухай бүр шинэчлэн гаргасан байх;	I-IV улиралд	Улсын хэмжээнд 2022-2024 онд шинээр ашиглалтанд орсон болон ашиглалтад орохоор төлөвлөж буй орон сууцны судалгаа, мэдээллийг гаргаж, Барилга, хот байгуулалтын яаманд 2022 оны 5

	орохоор төлөвлөж буй орон сууцны мэдээллийн судалгааг тухай бүр шинэчлэн гаргаж, мэдээллийн санг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;	- Орон сууцны мэдээллийн сангийн хөгжүүлэлтийн ажил хийгдсэн байх;		дугаар сарын 27-ны өдөр 1/1297 дугаар албан бичгээр, 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдөр 1/1665 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.
13	Иргэд, аж ахуй нэгж байгууллагад хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх, сорилт шинжилгээ хийлгэхэд барилгын материалын дээжийг дарааллын дагуу хүлээн авч, ирсэн дээжийг шинжилгээнд өгөх зорилгоор авлигад өртөх эрсдэл өндөр хэсгийг (<i>дээж хүлээн авах үүдний хэсэг болон зарлагын баримт хүлээн авч, шинжилгээнд ирсэн дээжний төлбөр хийх өрөө</i>) камерын хяналтад холбох;	Дээж хүлээн авах хэсэг болон өрөө камерын хяналтад холбогдсон байх;	I-улиралд	Лабораторийн байрны 1 дүгээр давхар 2 ширхэг камерын системд холбогдсон бөгөөд иргэд, аж ахуй нэгж байгууллагад хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх, сорилт шинжилгээ хийлгэхэд барилгын материалын дээжийг дарааллын дагуу хүлээн авч, ирсэн дээжийг шинжилгээнд өгөх
14	ХАНСЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд туслан болон гэрээт ажилтныг сонгон шалгаруулах ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулж, талуудын хооронд байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хариуцлагын заалтыг нэмж оруулах;	- Сонгон шалгаруулалтын ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар явагдсан байх; - Туслан болон гэрээт ажилтантай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлоос зөрчлөөс ангид ажиллах хариуцлагын заалт орсон байх;	Тухай бүр	Гэрээт ажилтан шалгаруулах зарыг <i>/тухай бүр/</i> өдрийн сонин болон байгууллагын вэб хуудас, фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэж, сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулан ажиллаж байна.
15	Хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах;	Байгууллагад хэрэглэгчийн үнэлгээ хийгдсэн байх;	I-III улиралд	Хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулсан.

16	<p>Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлж, авлигын индексийг бууруулах чиглэлээр тусгайлан арга хэмжээ зохион байгуулах;</p>	<p>Хэлтэс тус бүр тусгайлан арга хэмжээ зохион байгуулсан байх;</p>	3-р сар	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженерүүд “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн хуудсыг үнэн зөв бөглөж хэвшсэн.</p>
			4-р сар	<p>МУИС-ийн Олон Улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Нийтийн удирдлагын тэнхим, Төрийн удирдлагын хөтөлбөрийн багш, АТГ-ын сургагч багш Г.Мягмар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр төвийн нийт ажилтнуудад орж, мэдээлэл хүргэсэн.</p>
			5-р сар	<p>УИХ-ын дэргэдэх парламентын судалгааны төвийн захирал Ц.Цогзолмаа “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдөр төвийн нийт ажилтнуудад орж, мэдээлэл хүргэсэн.</p>
			6-р сар	<p>Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газраас “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2022 оны</p>

				6 дугаар сарын 10-ны өдөр төвийн нийт ажилтнуудад орж, мэдээлэл хүргэсэн.
			7-р сар	ССМХ
			8-р сар	ББМҮХ
			9-р сар	НАХХ
			10-р сар	ХАНБНСТХ
			11-р сар	СТХХ
			12-р сар	ХСДБСТХ

.....oOo.....